



**НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 4/30

Улаанбаатар хот

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
дөрөвдүгээр хуралдааныг хуралдуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр хуралдааныг 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 14:00 цагт хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- 1.1 Хурлын хороод байгуулах тухай
- 1.2 Дүүргийн 2020 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай
- 1.3 Дүүргийн 2021 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2. Ээлжит хуралдааны бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАЯР

1130100060